



**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/61

Улаанбаатар хот

Г Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан Г  
хариу арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн 110/35/10КВ дэд станцад гэмтэл гарсантай холбогдуулан урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн төв (Х.Ганбат), Цагдаагийн хэлтэс (Т.Лхагвасүрэн), Онцгой байдлын хэлтэс (Б.Цогбадрах), Илч-Орд ОНӨААТҮГ (Д.Гантулга), Ус суваг ашиглалтын товчоо (Н.Батсайхан), Хороодын Засаг дарга (Н.Нямзав, Б.Батзориг), Аж ахуйн нэгж, байгууллагын дарга эрхлэгч, захирал нарт дараах ажлыг үүрэг болгосугай.

1.1. Дэд станцын гэмтэл засагдах хүртэл цахилгаан үүсгүүрийн бэлэн байдлыг ханган цэвэр ус, дулаан хангамж, хэрэглээний халуун усаар иргэдийг хангах, бохир усыг татан зайлуулах хэвийн найдвартай байдлыг ханган ажиллах;

1.2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний найдвартай байдлыг хангаж, дуудлага хүлээн авах утсыг тогтмол ажиллуулан байгууллагын үйл ажиллагааны хэвийн нөхцөл байдлыг алдагдуулахгүйгээр байх;

1.3. Гэмт хэрэг, гамшиг ослоос урьдчилан сэргийлэн холбоо харилцааны найдвартай бэлэн байдлыг хангаж ажиллах;

1.4. Цахилгаан эрчим хүчний гэмтлийн талаар хороодын иргэдэд үнэн зөв мэдээлэл хүргэх;

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Ажил 2023 захирамж

1123000174